



**ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН
СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИХ
“БАРУУН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО
ЗАМААС ХОВД АЙМГИЙН
МӨНХХАЙРХАН СУМ ЧИГЛЭЛИЙН 65 КМ
АВТО ЗАМ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2022 он



**ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИХ “БАНУУН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМААС
ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН СУМ ЧИГЛЭЛИЙН 65 КМ АВТО
ЗАМ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ЭКОСЕРВИС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ:



..... **Ч.СОНОМДАГВА**

ЗАХИАЛАГЧ:

“ГЕОЗУРАГЛАЛ” ХХК-ИЙН ДЭД ЗАХИРАЛ:



..... **Ж.Батнасан**

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	1
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	1
1.2 Төслийн байршил.....	2
1.3 Төслийн талбайн мэдээ	2
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	4
2.1 Уур амьсгал	4
2.2 Агаарын чанар.....	6
2.3 Гадаргын ус болон газар доорх усны чанарын төлөв байдал	9
2.4 Газрын гадарга, хэвлий	11
2.5 Хөрсөн бүрхэвч	12
2.6 Ургамлан нөмрөг	15
2.7 Ан амьтан	18
2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалт зүйлс.....	19
2.9 Нийгэм, эдийн засаг	26
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	35
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	36
ХАВСРАЛТ	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил	2
Зураг 2. Ховд хотын 2004-2020 он хүртэлх агаарын чанарын үзүүлэлт.....	6
Зураг 3. Ховд хотын агаарын чанарын үзүүлэлт, сараар.....	7
Зураг 4. Төслийн агаар чанарын мониторингийн цэгийн байршил.....	8
Зураг 5. Төслийн талбайн агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцрын агууламж	8
Зураг 6. Төслийн талбайн агаар дахь том ширхэглэгт тоосонцоын агууламж.....	9
Зураг 7. Мөнххайрхан сумын гадаргын усны рН	10
Зураг 8. Мөнххайрхан сумын гадаргын усны цахилгаан дамжуулах чанар	11
Зураг 9. Төслийн талбайн хөрсний цэгийн байршил	12
Зураг 10. Ховд аймгийн хүн амын өсөлт ба хүйсийн ялгаагаар, 2015-2019.....	26
Зураг 11. Ховд аймгийн иргэдийг насны бүлгээр, 2019.....	28
Зураг 12. Ховд аймгийн төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, 1000 хүнд ногдохоор сүүлийн 5 жил.....	29
Зураг 13. Ховд аймгийн Мөнххайрхан сумын иргэдийг насны бүлгээр, 2019	29
Зураг 14. Ховд аймгийн өрхийн тоон мэдээлэл.....	30
Зураг 15. Төсөл хэрэгжих аймаг, сумын өрхийн тоон мэдээлэл.....	31
Зураг 16. ЕБС-д суралцдаг сурагчдын тоо.....	31
Зураг 17. ДНБ-ний гүйцэтгэл, салбар.....	32
Зураг 18. 2012-2019 оны хооронд Ховд аймагт ашиглалтад орсон орон сууцны тоо.....	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайд хөрсний зүсэлт хийсэн цэгийн координат (Ховд аймаг, Мөнххайрхан сум).....	14
Хүснэгт 2. Хөрсний шинжилгээний үр дүн.....	14
Хүснэгт 3. Төслийн талбайн механик бүрэлдэхүүн	15
Хүснэгт 4. Ховд аймгийн иргэдийг насны бүлгээр, 2017-2019	26

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан


БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

№	Төслийн нэр:	Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 64км авто замын ТЭЗҮ, инженерийн нарийвчилсан зураг төсөл
1	Төсөл хэрэгжүүлэгч: Улсын бүртгэлийн дугаар: Регистрийн дугаар: Факс:	Гео зураглал ХХК 9019045054 5169712 11312897
2	Төслийн санхүүжүүлэгч	Улсын төсөв
3	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	СБД 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 13-06 тоот
4	Төслийн байршил:	Ховд аймаг Мөст, Мөнххайрхан сумын нутаг
5	Төслийн зорилго:	Олон улсын болон улсын чанартай авто замуудад түшиглэн сумын төвийг хатуу хучилттай замтай холбосноор орон нутгийн иргэдэд хүргэж буй худалдаа үйлчилгээг чанартай, түргэн шуурхай хүртээх, орон нутагт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх.
6	Төслийн ач холбогдол:	Ховд-Мөнххайрхан чиглэлийн авто зам нь ачаа тээвэр, зорчигч тээвэр, аялал жуулчлалын замын сүлжээг өргөтгөх чухал ач холбогдолтой замын чиглэл болох юм.
7	Төслөөс гарах үр дүн:	Сум орон нутгийн иргэдийн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг дээшлүүлэх, байгаль орчны сөрөг нөлөөг багасгах.
8	Төслийн талбай:	640 га
9	Төслийн хүчин чадал:	64км авто зам
10	Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц:	Эрчих хүчинд холбогдсон, юнител, мобиком сүлжээ орсон.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

1.2 Төслийн байршил



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.3 Төслийн талбайн мэдээ

БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар хурлын тогтоолоор Жаргалант төвтэй Ховд аймгийг Алтай, Алтантээл, Манхан, Үенч, Булган, Цагаанбулан(Мянгад), Буянт, Эрдэнэбүрэн, Дарви, Чандмань, Хайрхан, Цэцэг, Мөнххайрхан гэсэн 13 сумтай байгуулжээ.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх үндэслэл. Төслийн үйл ажиллагаа явуулахын тулд байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлыг гүйцэтгэхэд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7, 9 дүгээр зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6.1, 6.2, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот тушаалын хавсралтын дагуу Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний зорилт. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлын гол зорилго нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал тухайлбал, газарзүйн нөхцөл, геологийн тогтоц, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг мөн түүнчлэн нутгийн иргэд, оршин суугчид, тэдний нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрүүл мэнд, түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдлыг тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачид, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор, шинжлэх ухааны судалгааны аргазүйг үндэслэн тодорхойлох, байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тодруулах шаардлагатай нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдлыг илтгэх үзүүлэлтүүдийг гаргахад бүрэн чиглэгдэнэ.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хамрах хүрээ. Төсөл хэрэгжих газар болох Ховд аймгийн Мөнххайрхан сумын нийгэм, эдийн засгийн өнөөгийн төлөв байдлыг судалж баримтжуулан, шинээр бүтээн байгуулалт хийн ажиллахад нөлөө үзүүлж болзошгүй талбайг хамруулна.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний арга зүй. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлыг гүйцэтгэхэд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Монгол Улсын Засгийн Газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалын 2-р хавсралт /Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний аргачлал/-ыг баримтлан гүйцэтгэсэн ба дараах чиглэлээр тайланг боловсруулав. Үүнд:

- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт, шаардлага, үнэлгээний цар хүрээг тодорхойлох;
- Өмнөх судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, байгаль орчны төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх;
- Судалгааны мэдээллийг эмхэтгэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан боловсруулах зэрэг болно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Уур амьсгал

Жилийн дундаж хэм нь -0,4-1,9 хэм. Хүйтэн урт өвөлтэй, аагим халуун, богино зунтай, агаар нь хуурай, унах тунадасны хэмжээ бага. Нийт нутгаар жилд 220мм-ээс ихгүй тунадас буудаг. Уулархаг хэсэгтээ хамгийн ихдээ 300мм хүртэл, говь цөлийн бүсдээ 50мм хүртэл хур тунадас буудаг.

Ховд аймгийн газар нутгийн тэгш бус байдал нь уур амьсгалыг бүрэлдүүлэгч гол хүчин зүйлсийн нэг юм. Тус хот нь тал бүрээрээ өндөр уул, нуруугаар хүрээлэгдэн оршдог эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм. Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалын өргөрөгийн болон өндрийн бүслэлд тодорхой илэрсэн байдаг.

Мөнххайрхан уул, түүний орчимд ерөнхийдөө хур тунадас багатай, өвөл зун, өдөр шөнийн температурын ялгаа ихтэй, эх гадрын хуурайвтар сэрүүн уур амьсгалтай. Хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур 17-24 градус, 7-р сарынх 12-с 15 (нэмэх) градус, жилийн дундаж нь 1-3 градусорчим байна.

Төслийн объект болох Ховд аймгийн Мөнххайрхан сум нь эх газрын уурын уур амьсгалтай. Зун +40 хэм хүрч халдаг боловч өвөл -30 хэм хүртэл буурдаг. Харьцангуй хуурай. Хур тунадасны дундаж хэмжээ 120мм-140мм, 1-р сарын дундаж температур -17 хэм (-25.5), 7-р сарын дундаж температур +16.5 хэм, салхины хурд 4.5м/сек хүрнэ, хамгийн хүйтэн улиралд агаарын температур -40 хэм хүртэл буурч, хамгийн дулаан улиралд +35 хэм хүрч, бүртгэгдсэн салхины хамгийн дээд хурд 1.0м/сек байв. Хавар, намрын улирал харьцангуй урт бөгөөд тус бүр 120-160 хоног байна:

Агаарын температур

Уур амьсгалын өөрчлөлтийг тодорхойлогч гол хүчин зүйлийн нэг бол агаарын температур юм. Ховд хот орчмын олон жилийн агаарын температур нь -0.3°C бөгөөд 1985-2012 оны хандлагын өөрчлөлтийг графикаас харахад Ховд хот

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

орчим сүүлийн 28 жилд агаарын дундаж температур 1.1°C-аар дулаарчээ. 1985- 2004 он хүртэл агаарын дундаж температур харилцан адилгүй өссөн бөгөөд 2005 онд агаарын дундаж температур -1.0°C хүрч буурсан байна.

Агаарын үнэмлэхүй их температурын олон жилийн явцаас харахад Ховд хотод °C-аар дулаарсан хандлага ажиглагдаж байна. Агаарын үнэмлэхүй их температур 1985-1992 он хүртэл өсөөд, 1993 онд буурч 1994-2012 он хүртэл өссөн байна. Агаарын температурын үнэмлэхүй их нь 2004 оны 07-р сард 37°C хүрсэн.

Агаарын үнэмлэхүй бага температур

Агаарын үнэмлэхүй бага температурын олон жилийн явцаас харахад Ховд хотод 1.1°C-аар дулаарсан хандлага ажиглагдаж байна. Агаарын температурын үнэмлэхүй бага нь 2005 оны 02-р сард -43°C хүрч хүйтэрсэн байна.

Хөрсний гадаргын температур

Хөрсний гадаргын дулааны горим нь тухайн нутаг орны онцлог, хөрсний төрөл бүтэц, чийгээс хамаардаг. Доорхи зурагнаас харахад хөрсний жилийн дундаж температур нь 1.6°C-аар дулаарсан хандлагатай байна. Хөрсний гадаргын температур 1985-2012 он хүртэл харилцан адилгүй өссөн хандлага ажиглагдсан.

Агаарын чийгшил


Жилийн хамгийн их утга нь өвлийн саруудад ажиглагдах ба 70-80% байхад хавар чийгийн хамгийн бага утга ажиглагдсан байна. Тухайн газар нутгийн агаарын чийгийн их, бага хуурайшилтыг үзүүлэх нэг үзүүлэлт бол хоногийн аль нэг хугацаанд 30%-аас бага, 80%-аас их чийг ажиглагдсан өдрийн тоо юм. Харьцангуй чийгийн олон жилийн явцаас харахад 1985-2001 он хүртэл буурч, 2002-2005 он хүртэл өсөөд, 2006-2012 он хүртэл дахин буурсан хандлага ажиглагдаж байна. Энэхүү судалгааны ажлаас дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

1. Агаарын дундаж температур сүүлийн 28 жилд 1.1°C-аар дулаарсан байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур 1998 онд 36.6 °C, 2001 онд 36.7 °C, 2004 онд 37.0 °C хүрч их халуун ажиглагдсан байна.
2. Хур тунадасны хувьд жил жил харилцан адилгүй өөрчлөгдсөн бөгөөд 2001 онд хамгийн бага хур тунадас 84мм, хамгийн их хур тунадас 2003 онд 223.4мм хур тунадас унасан байна.
3. Харьцангуй чийг 1985-2001 он хүртэл буурч, 2002-2005 он хүртэл өсөөд, 2006-2012 он хүртэл дахин байгаа нь хуурайшилт нэмэгдэх нөхцөл бий болж байна.
4. Ховд хотын орчмын шороон шуурга, хүчтэй салхины давдагтал ихсэж байгаа нь хөрсний эвдрэл, элсний нүүлт болох гол шалтгаан болж байна.

2.2 Агаарын чанар

Төслийн талбайн агаарын чанарын хувьд Цаг уур орчны шинжилгээний газрын мэдээ болон хээрийн хэмжилтийн мэдээний үндсэн дээр тодорхойлсон болно.




Зураг 2. Ховд хотын 2004-2020 он хүртэлх агаарын чанарын үзүүлэлт

Эх сурвалж: УЦУОШГ

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

Зураг 2-оос харахад азотын давхар исэл нь Монгол улсын агаарын чанарын стандартыг сүүлийн 8 жилийн хугацаанд тасралтгүй давсан үзүүлэлттэй байна. Харин хүхэрлэг хийн агууламж стандарт хэмжээнээс бага байна.



Зураг 3. Ховд хотын агаарын чанарын үзүүлэлт, сараар
Эх сурвалж: УЦУОШГ

Зураг 3-т Ховд хотын агаарын чанарыг агаар дахь бохирдуулагч бодисын хэмжээг II сараас XI сар хүртэлх хүхэрлэг хийн (SO₂) дундаж болон хамгийн их, хамгийн бага утгуудыг сарын интервалтай илэрхийлсэн. XII сарын хүхэрлэг хийн (SO₂) дундаж агууламж нь 18 мкг/м³ буюу бусад саруудас хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бол VII сард хамгийн бага буюу 2 мкг/м³ байна.

Харин Ховд аймгийн Мөнххайрхан сумын агаарын чанарын харуулын ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.027 мг/м³, хамгийн их нь 0.040 мг/м³, хамгийн бага нь 0.014 мг/м³, азотын давхар ислийн дундаж агууламж 0.046 мг/м³, хамгийн их нь 0.068 мг/м³, хамгийн бага нь 0.022 мг/м³, нүүрстөрөгчийн дутуу ислийн дундаж агууламж 3.54 мг/м³, хамгийн их нь 5.28 мг/м³, хамгийн бага нь 1.50 мг/м³ байна. Агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж хүлцэх хэмжээнээс даваагүй байна.


Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

Төслийн талбайн агаарын чанарын төлөв байдал

2022 оны 09 сарын 20-ны өдөр төслийн талбайн агаар дахь том болон нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжилтийг арга аргачлалын дагуу хэмжиж MNS 4585:2016 стандарттай харьцуулан үзүүллээ.



Зураг 4. Төслийн агаар чанарын мониторингийн цэгийн байршил




Зураг 5. Төслийн талбайн агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцрын агууламж

2022 оны 9 сарын 20-ны өдрийн хээрийн судалгаагаар төслийн талбайн агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд Монгол улсын агаарын чанарын стандартыг давсан

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

үзүүлэлтгүй байна. Дундаж агууламж нь 5 мкг/м^3 , хамгийн их агууламж нь 39 мкг/м^3 , хамгийн бага агууламж нь 2 мкг/м^3 байжээ.



Зураг 6. Төслийн талбайн агаар дахь том ширхэглэгт тоосонцоын агууламж

2022 оны 9 сарын 20-ны өдрийн хээрийн судалгаагаар төслийн талбайн агаар дахь том ширхэглэгт тоосонцрын хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд Монгол улсын агаарын чанарын стандартыг давсан үзүүлэлтгүй байна. Дундаж агууламж нь 10 мкг/м^3 , хамгийн их агууламж нь 138 мкг/м^3 , хамгийн бага агууламж нь 2 мкг/м^3 байжээ.

2.3 Гадаргын ус болон газар доорх усны чанарын төлөв байдал

Мөнххайрхан уулын ноён оргил нь 4362 метр өндөр бөгөөд мөнх цас мөсөн гол бүхий Монголын хоёр дахь өндөр оргил болно. Мөнх цас мөсөн гол нь 200-гаад хавтгай дөрвөлжин километр талбайг эзлэн оршино. Монгол Алтайн нжржжны мөсөн голуудын дундаж зузаан нь 130 гаруй метр хүрч тус орны гол мөрний нийлбэр урсацаас бараг 2 дахин, газар доорхи хөдөлгөөнт усны нөөцөөс 5 дахин их цэвэр усны нөөц хадгалагдаж байгааг судлаачид тогтоосон байна.

Гол мөрөн, нуурын усны чанарыг ууссан хүчилтөрөгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, перманганатын исэлдэх чанар, биогенийн элементүүд буюу аммонийн азот, нитритийн азот, нитратын азот, эрдэс фосфор зэрэг үзүүлэлтээр голлон тодорхойлно.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

- ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ: устөрөгчийн ион (pH), цахилгаан дамжуулах чанар, перманганатын исэлдэх чанар, ууссан хүчилтөрөгч (O₂), биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ5), зэргийг тодорхойллоо.




Зураг 7. Мөнххайрхан сумын гадаргын усны pH

Эх сурвалж: <http://khovd.tsag-aqaar.gov.mn/environment/water>

- АММОНИЙН АЗОТ/ $\text{NH}_4\text{-N}$ /- энэ элемент нь дээрх химийн элементүүдээс голын усанд хамгийн түгээмэл илэрдэг бөгөөд манай орны гол мөрний усанд ихэнхдээ 0.5 мг/л-ээс үл хэтэрдэггүй. - УСНЫ ХҮЧИЛЛЭГ, ШҮЛТЛЭГ БАЙДАЛ /pH/- аливаа усан орчны хүчиллэг ба шүлтлэг чанарыг устөрөгчийн ионы /pH/ агууламжаар тодорхойлно.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

- ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ЧАДВАР /ЕС/- усны химийн найрлага, эрдэсжилттэй шууд хамааралтай, түүнийг илтгэгч хэмжигдхүүн юм.



Зураг 8. Мөнххайрхан сумын гадаргын усны цахилгаан дамжуулах чанар

Эх сурвалж: <http://khovd.tsag-agaar.gov.mn/environment/water>

2.4 Газрын гадарга, хэвлий

Газрын гадарга: Гадаргын хувьд аймгийн нутаг нь говь цөл, тэгш тал, ухаа гүвээт тал, нам уулс, дундаж өндөр уулс, уулс хоорондын хотос хонхор, цав толгод гэсэн хотгор гүдгэрийн бүх хэв шинжүүд илэрдэг. Гадаргын хамгийн өндөр цэг нь Мөнххайрхан уул (4204м), хамгийн нам цэг нь Зүүнгарын говь дахь Бор цонжын тал 1126м юм.

Төв Азийн цөлийн нөлөөлөлд орших хязгаарлагдмал эмзэг нөхцөлд бүрэлдэн тогтсон цэвдэг, мөсөн голууд бүхий өвөрмөц ландшафтыг улсын тусгай хамгаалалтад авснаар байгалийн цэвэр усны асар их нөөцийг хадгалж, хамгаалах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ мөнх цас, мөсөөр тэжээгддэг Алтайн нурууны ар, өвөр хажуугаас эх аван урсах их, бага олон голуудын эхийг хамгаалах, хөрсний чийгийн горимыг тогтвортой байлгах чухал ач холбогдолтой юм. Монгол Алтайн мөсөн голуудын дундаж зузаан 56 м байдаг бол Алтай Таван богд, Мөнххайрхан уулын мөсдлийн төвүүд 130 гаруй метр хүрч нийт мөсөн голын нөөц ус 63 миллиард шоо хүрдэг.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

2.5 Хөрсөн бүрхэвч

Ховд аймаг нь Монгол Алтайн нурууны хойт өргөгдөл болох хүчтэй хэрчигдэлд орсон дунд өндөрлөг бүхий Хөх Сэрхийн нуруу, Хар үзүүр уул, Ботгон уул, Баатархайрхан зэрэг уул нуруудаар хүрээлэгдэн оршино. Хотын нутаг нутаг дэвсгэр нь уулын бэлээс голын хөндийд шилжих хэсэг бөгөөд өндөржилт 1300-1400 метр, харьцах өндрийн зөрүү 200-350 метр нутаг дэвсгэрийн өргөн 5-6 км, газрын гадаргуугын налуу 2-3 град орчим байна.

Хөрсний гадаргын олон жилийн дундаж температур 0.00-3,4 град, хөрс нутаг дэвсгэрийн хэмжээнд 3.2м гүн хөлддөг, нийт талбайн хэмжээнд олон жилийн цэвдэг хөрс тохиолдохгүй. Хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд Денудаци-хуримтлалын, хуримтлалын, гол татмын, татмын дээрхи дэнжийн гэсэн гадаргуугын 4 хэв шинж илэрдэг.


Геологийн тогтоцын хувьд Хойт Монголын атираат системд хамаарагдах бөгөөд геологи, газарзүйн мужлалаар Их нуруудын хотгорын баруун хойт захын дунд өндөрлөг уулс бүхий Зэргийн грабел антикинал бүсэд байрлана.



Зураг 9. Төслийн талбайн хөрсний цэгийн байршил

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

Хөрс №1



Хөрсний дээж-1	
А үе	Байхгүй
В үе	0-25 см Ургамлын үндэс бага Сайргархаг цайвар хүрэн хөрс
С үе	25 см-аас доош Ургамлын үндэс байхгүй Сайргархаг хүрэн хөрс

Солбилцол: N 47° 2'58" E 91° 50'55" ДТД: 2100м

Хөрсний дээж №2



Хөрсний дээж-2	
А үе	0-18см Ургамлын үндэстэй Сайргархаг хүрэн хөрс
АВ үе	18-30см Ургамлын үндэс бага Сайргархаг цайвар хүрэн хөрс
В үе	30см-с доош Ургамлын үндэс байхгүй Сайргархаг хүрэн хөрс

Солбилцол: N 46° 54'35" E 92° 15'29 ДТД: 2840

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

Хүснэгт 1. Төслийн талбайд хөрсний зүсэлт хийсэн цэгийн координат (Ховд аймаг, Мөнххайрхан сум)

Хөрсний зүсэлт №	Өргөрөг	Уртраг
Мөнххайрхан сумын төв	N 47° 2'58"	E 91° 50'55"
Мөнххайрхан сумаас 10км-ийн зайд	N 46° 54'35"	E 92° 15'29"

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

Хүснэгт 2. Хөрсний шинжилгээний үр дүн

№	Дээжний нэр	рН	Давс %	Цдч dsm	Ялзмаг, %	СаСо ₂ %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Са	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	Хөрс -1	7.26	0.03	0.061	1.56	0.00	12.3	3.7	2.0	47
2	Хөрс-2	6.80	0.02	0.051	3.52	0.00	14.5	5.5	2.9	34

Хүснэгт 2-т Хөрсний уусмал дахь устөрөгчийн ионы хэмжээг аравтын урвуу логарифмаар илэрхийлснийг хөрсний хүчиллэг буюу рН гэнэ. Төслийн талбайн хөрс №1-ийн рН нь 7-оос их учир шүлтлэг, хөрс №1-ийн рН нь 7-оос бага учир хүчиллэг байна.

Хөрсөн дэх давсны хуурай үлдэгдэл нь 0.25%-иас их болсон тохиолдолд давстай хөрс гэж үздэг. Гүний ус гадаргад ойрхон оршиж, ууршилт угаагдлаас их байх нөхцөлд хөрсний тодорхой хэсэгт хялбар уусах давс хуримтлагдах үйл явц ихэсдэг. Төслийн талбай дахь хөрсний давсны агууламж болон цахилгаан дамжуулах чанараас үзвэл хөрс нь давсжилтгүй зэрэглэлд багтаж байна.

Ялзмаг нь хөрсний үржил шимийг тодорхойлох үндсэн үзүүлэлт болох ба ялзмагийн агууламж их байх тусам хөрсний ус, агаар, дулааны болон физик-механикийн шинж чанар сайн байна. Монгол орны хөрс ерөнхийдөө бага ялзмагтай байдаг ба хөрсний хэв шинжээс шалтгаалан харилцан адилгүй байна. Төслийн талбайн хөрс нь цайвар хүрэн хөрс байсан ба ерөнхийдөө хүнд механик бүрэлдэхүүнтэй хар хүрэн хөрсний ялзмагийн агууламжнаас бага

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

байдаг. Шинжилгээний дүнгээс харахад ялзмагийн агууламж 1.56-3.52-н хооронд байна.

Хөдөлгөөнт фосфор нь органик үлдэгдэл, ялзмаг ба эрдсийн найрлагад агуулагдана. Фосфор ургамлын эсийн бөөмний бүрэлдэхүүнд орох ба ургамлын үрийн найрлагад их, сүрэлд бага агуулагдана. Хөрсөнд фосфор нь дунджаар 0.08% агуулагдана.

Хөдөлгөөнт кали нь ургамлын хооллолтонд усанд уусдаг ба солилцох кали нь ихээхэн үүрэгтэй байдаг.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хүснэгт 3. Төслийн талбайн механик бүрэлдэхүүн

№	Дээжний нэр	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ,мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001>	<0.01
1	Хөрс-1	19.8	47.2	18.7	1.7	6.1	6.4	14.3
2	Хөрс-2	38.2	26.1	23.9	7.0	3.8	1.0	11.8

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390 :2001, MNS 6824:2020)

Хүснэгт 3-т хөрсний механик бүрэлдэхүүнийг харуулсан байна. 2 хөрсний дээжийн хувьд 1-0.25, 0.25-0.05 ширхэглэгтэй хөрс давамгайлж байна.

2.6 Ургамлан нөмрөг

Мөнххайрхан уулын орчмын нутагт 61 овгийн 241 төрлийн 690 зүйлийн ургамал байдгаас 98 зүйл нь мод, сөөг, 592 зүйл нь өвслөг ургамал юм. Мөнххайрхан уулын районд уулын бэл хормой, хотгоруудаар сөөгөнцөр-сайрын хялганат, таана-сайрын хялганат, баглуур-таана-сайрын хялганат цөлийн хээр, ботууль-дааган сүүл-невскийн ерхөгт, ботууль-невскийн ерхөгт, дэгнүүл үетэнт хээр (дэрвээн хазаар өвс, крыловын хялгана, саман хиаг), хуурай хээрийн ургамалшилтай байдаг бол дээшээгээ өгсөх тутам уулын хээрийн дэгнүүл үетэнт (*Festuca lenensis*, *Poa attenuata*, *Koeleria cristata*), өндөр уулын хээрийн алаг өвс-дэгнүүл үетэнт, өндөр уулын улалжит нугажуу хээр (*Carex pediformis*,

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

Festuca lenensis, *Poa attenuata*, *Koeleria cristata*)-ийн хэвшинжүүд голлох шинжтэй болж ирнэ.

Өндөр уулын хээрт олонхи тохиолдолд *Stipa krylovii*, *Festuca lenensis* зонхилно. Үенч, Улиаст зэрэг голуудын татамд сөөгөн шугуй байхаас гадна улаан харганын ширэнгэ бүхий цахилдаг - үетэнт, үетэн - алаг өвс - ширэг улалжит (*Iris bungei*, *Elymus angustus*, *Hordeum brebisubulatum*, *Calamagrostis macilenta*, *Agrostis trinii*) бүлгэмдэл зонхилно. Мөн *Populus laurifolia*, *Salix ledebouriana*, *Hippophae rhamnoides* элбэг ургана. Улиаст, Харгайт орчмоор ойн ургамалжилт уулын ар сугаар мэр сэр тааралдана. Ой бүрдүүлэгч нь шинэс бөгөөд үлдмэл шинжтэй тохиолдоно. Ой дотор *Lonicera altaica*, *Rosa acicularis* гэсэн хоёр зүйлийн сөөг, өвслөг ургамлаас *Festuca altaica*, *F. lenensis*, *Kobresia bellardii*, *Polygonum viviparum*, *Oxytropis alpina*, *Saussurea sumnevicz*, *Thalictrum minus* гэх мэт зүйл ургана. Өндөр уулын бүслүүрийн хэвшинж нь тачир ургалттай бушилзат (*Kobresia*), улалжит (*Carex*) нуга юм. Энэ нутгийн ялгарах нэг онцлог нь хадны улалжит (*Carex rupestris*) нуга түгээмэл тархалттай бөгөөд түүний бүрэлдэхүүнд *Carex tenuiflora*, *C. melanantha*, *Kobresia bellardii*, *K. smirnovii* зэрэг зүйлүүд элбэг тохиолдоно (Ганболд, 2003).

Ашигт ховор ургамал. Алтайн сонгино, хонин арц, вансэмбэрүү, ямаан сэрдэг, хуурамч арц, цагаан дэгд, жамъяанмядаг, алтан гагнуур, өргөст ортууз, таван салаа, балгана мод зэрэг ургамал ургадаг. Булган голын сав, Алтайн өвөр говийн дэд мужид хонхот харгана, сухай, залаархаг хавраг буюу чийр, чачаргана, цагаан гоёо, улаан гоёо, сармисан сонгино зэрэг нэн ховор, ховор ургамал тархан ургадаг.

Мөнххайрхан уул, түүний орчимд ерөнхийдөө хур тундас багатай, өвөл зун, өдөр шөнийн температурын ялгаа ихтэй, эх газрын хуурайвтар сэрүүн уур амьсгалтай. Хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур-17-24 С, 7-р сарынх+ 12+15 С, жилийн дундаж нь -1-3 С орчим байна. Мөнххайрханы нуруу нь ховор, ховордсон амьтан, ургамлын олон зүйлийн шүтэн амьдрах нэн чухал газар учраас улсын тусгай хамгаалалтанд хамруулсан болно.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан




Ургамлын бичиглэл нэгж талбар 1

Бичиглэл хийсэн цэгийн координат: ЗУ 92°1'59", ХӨ 47°0'45"

Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 25-30%.

Уулын далд глейрхэг хүрэн шороон хөрсөнд тархсан уулын хээрийн бэлчээрийн ерөнхий цайвар ногоон. Өнгө үзүүлэгч ургамал үетэн алаг өвс. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 30-35%. Ургамлын дундаж өндөр 2-4см. 1м²-д зүйлийн тоо 3 байна. Эдгээрт нь монгол өвс-баглуур, хонин зээргэнэ зэрэг орно.

Бичиглэл хийсэн цэгийн координат: ЗУ 106° 59' 45", ХӨ 43° 7' 29". (Зураг 20)



Ургамлын бичиглэл нэгж талбар 2

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

Бичиглэл хийсэн цэгийн координат: ЗУ 92°1'59”, ХӨ 47°0'45”

Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 25-30%.

2.7 Ан амьтан

Амьтны аймгийн хувьд Иран-Туран, Алтай-Соён, Сибирийн тайга, Төв Азийн цөл, хээрийн амьтны төрөл зүйл харилцан нэвтэрч тархсан уулзвар нутаг юм. Олон улсын болон Монгол улсын Улаан номонд орсон, цаашид оруулбал зохих олон зүйлийн ховор амьтан бүхий дэлхий дээр өөр хаана ч байхгүй байгалийн өвөрмөц нандин цогцолбор мөн.

Мөнххайрхан ууланд Цоохор ирвэс (*Uncia uncia*), Янгир ямаа (*Capra sibirica*), Алтайн аргал хонь (*Ovis ammon ammon*), Тагийн огодой (*Ochotona alpina ssp. hoffmanni*), Алтайн тарвага (*Marmota baibacina*), Хадны барагчин (*Alticola argentatus*), Алтайн хойлог (*Tetraogallus altaicus*), Хилэн омруут ахууна (*Gavia arctica*), Цармын бүргэд (*Aquila chrysaetos*) зэрэг хөхтөн, мэрэгчид шувуудыг нэрлэж болно. Түүнчлэн аль ч экосистемд тохиолддог Саарал чоно (*Canus lupus*), Шар үнэг (*Vulpes vulpes*) элбэг бий. Мөн Монгол тарвага (*Marmota sibirica*), урт сүүлт зурам (*Citellus undulatus*), монгол огодой (*Ochotona pallasi*), бор туулай (*Lepus tolai*), дорго (*Meles meles*), саарал чоно (*Canus lupus*), шар үнэг (*Vulpes vulpes*), хярс (*Vulpes corsac*), тарважи бүргэд (*Aquila rapax*), сар (*Buteo hemilasius*), зээрд шонхор (*Falco naumanni*), начин шонхор (*Falco tinnunculus*) зэрэг элбэг тохиолдоно.

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн олон төрөл зүйл нэг дор оршдог 4 том тархац нутаг байдгийн нэгэнд Мөнххайрхан уулын дэд муж ордог (Мөнхбаяр, 2002). Монгол улсын улаан номонд орсон тойрмын хонин гүрвэл ганцхан Мөнххайрхан уулын дэд мужид бий.

Мөнххайрхан уул, түүний орчмын газар нутагт аргаль, янгир, буга, ирвэс, алтайн хойлог, ятуу, чоно, мануул, үен, суусар, голын халиу, минж зэрэг ан амьтан нутаглахаас гадна хоёр нутагтан мөлхөгчдийн олон төрөл зүйл нэг дор оршдог 4 том тархац нутгийн нэг юм. Монгол улсын улаан номонд орсон тойрмын хонин гүрвэл зөвхөн Мөнххайрхан уулын дэд мужид бий. Мөн ховорт

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

тооцогддог ногоон бах, үхэрдэй Булган голд, Алтайн нурууны эндемик дөрвөлжин далавчит царцаа энэ газарт элбэг байдаг.

2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалт зүйлс

Монгол улсын Их хурлын 2011 оны 18 дугаар тогтоолоор Ховд аймгийн Үенч сумын зарим газар нутгаас нийт 191000 га, Булган сумын нутагт орших Булган гол-Их Онгогийн БЦГ-ын нийт 92221 га газрыг Улсын тусай хамгаалалтанд авч, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 06 сарын 04-ний өдрийн А-218 дугаар тушаалаар Мөнххайрханы БЦГ-ын хамгаалалтын захиргаанд хариуцуулсан.

Мөнххайрхан уул, түүний орчмын газар нутаг нь Баян-өлгий аймгийн Булган сум, Ховд аймгийн Мөнххайрхан, Үенч сумын хил залгаа нутгийг дамнан 60-120 км-ийн өргөнтэйгээр баруун хойноос зүүн урагш 350 гаруй км үргэлжлэн оршдог.

Мөнххайрхан уулын ноён оргил нь 4362 м /д.т.д/ өндөр өргөгдсөн манай орны хоёр дахь өндөр оргил бөгөөд нурууны хяраас дээш 400-500 м өндөрт сүндэрлэдэг мөнх цас, мөсөн гол бүхий уул юм. Мөнххайрхан уул нь Монгол Алтайн нурууны өндөр уулын мужид томоохон байр эзэлдэг.

Ховд аймаг нь Монгол Алтайн уулс, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говийн ихэнх хэсгийг хамарсан 7.6 сая га нутаг дэвсгэртэй.

Тэгвэл одоогийн байдлаар аймгийн нийт газар нутгийн 52 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан гэж Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас мэдээллээ.

Тухайлбал, нийт газар нутгийн 2654576 га буюу 34.9 хувь нь улсын тусгай хамгаалалтад орсон байна. Харин 725765.1 га буюу 9.5 хувь нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт багтаж байна.

Төв Азийн цөлийн нөлөөлөлд орших хязгаарлагдмал эмзэг нөхцөлд бүрэлдэн тогтсон мөнх цэвдэг, мөсөн голууд бүхий өндөр уулын өвөрмөц ландшафтыг хамгаалалтад авснаар байгалийн цэвэр усны асар их нөөцийг хадгалж хамгаалах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ мөнх цас, мөсөөр тэжээгддэг Алтайн

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто зам” төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

нурууны ар, өвөр хажуугаас эх авч урсдаг их, бага олон голуудын эхийг хамгаалах, хөрсний чигийн горимыг тогтвортой байлгах чухал ач холбогдолтой юм. Иймээс Мөнххайрхан уул, түүний орчмын газар нутгийг 2006 онд УИХ-ын 26 дугаар тогтоолоор нийт 301144.011 га талбайг улсын тусгай хамгаалалтанд авсан.

Цамбагарав уул

